2019 оны 03 сарын 22-ны өдөр Дугаар А/229 Улаанбаатар хот

Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “а”, 29.2, Иргэний хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6, Төрийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.4, Засгийн газрын 2019 оны 100 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах хэрэгжүүлэгч агентлагуудыг шинэчлэн тогтоож, нийслэлийн “Мэдээллийн технологийн газар”-ыг “Мэдээлэл, технологийн газар” болгон өөрчилсөнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд тус тус үүрэг болгосугай:

1.1.Байгууллагын дүрэм, гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан тушаалын тодорхойлолтыг 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор шинэчлэн боловсруулж, батлуулахыг Нийслэлийн Мэдээлэл, технологийн газрын даргад;

1.2. Өөрчлөн зохион байгуулагдаж байгаа агентлагийн үйл ажиллагааны зардлыг тооцож, шаардагдах хөрөнгийг 2019 оны төсөвт өөрчлөлт оруулах замаар санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т;

1.3. Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр үүрэгт ажлаас чөлөөлөгдөж байгаа албан хаагчдыг Төрийн албаны хууль тогтоомжид заасан баталгаагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Мэдээлэл, технологийн газрын даргад.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажил хүлээлцүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /М.Отгонбаяр/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ С.АМАРСАЙХАН

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
03 дугаар сарын 22-ны өдрийн
А/229 дүгээр захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга	-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга М.Эрдэнэжаргал
Гишүүд:	-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Ү.Ганболд;
	-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Б.Жавзмаа;
	-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн А.Баттөмөр;
	-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Ууганжаргал;
	-Нийслэлийн Өмчийн харилцааны газрын мэргэжилтэн Б.Эрдэнэчулуун;
	-Нийслэлийн Архивын газрын мэргэжилтэн Ж.Болорчимэг.
Нарийн бичгийн дарга	-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн М.Намсрайхүү